



Сүрьеэ өвчний талаар хамгийн ихээр тавигддаг асуултууд ба хариултууд

1. Сүрьеэ гэж юу вэ?

Сүрьеэ бол сүрьеэгийн нянгаас (*Mycobacterium tuberculosis*) үүсдэг халдварт өвчин юм. Хамгийн элбэг тохиолддог хэлбэр нь уушигний сүрьеэ (ойролцоогоор 70%). Тунгалагийн зангилааны сүрьеэ, ясны сүрьеэ гэх мэт бусад хэлбэрүүд нь халдваргүй байдаг.

2. Сүрьеэгийн нууц халдвар гэж юу вэ?

Амьдарлынхаа ямар нэг үед сүрьеэгийн нянтай ойртож, халдвар авсан бол түүнийг сүрьеэгийн нууц халдвар гэж нэрлэнэ. Энэ үе шатандаа тухайн хүн өвчтэй биш, халдвартай ч биш. Ийнхүү халдвар авсан хүмүүсийн ихэнх (ойролцоогоор 90%) нь сүрьеэгээ огт өвчилдөггүй.

3. Сүрьеэ яаж тархдаг вэ?

Сүрьеэгийн нян хүнээс хүнд агаараар дамжин тархдаг. Өвчилсөн хүн ханиахдаа орчин тойрныхоо агаарт сүрьеэгийн нян агуулсан бичил дуслуудыг гадагшлуулан тараана. Тэдгээр нь хэсэг хугацаанд агаарт хөвөн, бусад хүмүүсийн бие махбодид амьсгалын замаар дамжин нэвтэрнэ. Халдвар авах аюул зөвхөн уушигны халдварт өвчинтэй хүнтэй ойртсон тохиолдолд л байна (6-р асуултыг үз).

4. Ямар тохиолдолд сүрьеэгээр өвчилсөн гэж үзэх вэ?

Уушгинд нян үржиж байгаа тохиолдолд сүрьеэгээр өвчилсөн гэж үзнэ. Энэ нь халдвар авснаас хойш хэдэн сар, хэдэн жилийн дараа ч байж болно. Сүрьеэгийн нян цусны сувгуудаар дамжин бүх биед тархаж болно (ж: тунгалагийн зангилаа, мэдрэлийн төв систем, яс). Сүрьеэгийн энэ хэлбэрүүд нь халдваргүй. Сүрьеэ өвчин ялангуяа бага насны хүүхдүүд буюу дархлал нь сульдсан хүмүүсийн хувьд аюултай. Өнөө үед сүрьеэг зөв эмчилвэл эдгэрэх бололцоо бүрэн бий.

5. Сүрьеэгээр өвчлөхөд ямар хэвшмэл шинж тэмдгүүд илрэх вэ?

Өвчлөл ихэнхдээ ялихгүй шинж тэмдгүүдээс эхэлдэг. Эдгээр нь ханиалгах (заримдаа цустай цэрээр), амархан ядрах, хөнгөн халуурах, шөнөдөө хөлрөх зэрэг байж болно. Дараагийн үе шатанд турах, хоолонд дургүй болох, цээж өвдөх гэх мэт бусад шинж тэмдгүүд илэрнэ.

6. Сүрьеэг хэзээ халдвартай гэж үзэх вэ?

Уушгинд өвчин даамжирч, өвчтөн ханиахдаа (эсвэл найтаахдаа) сүрьеэгийн нян гадагшлуулж эхэлсэн тохиолдолд уушигны халдварт сүрьеэ гэж үзнэ. Зөвхөн энэ үе шатанд хүрсэн өвчтөн л сүрьеэгийн нянг дамжуулж бусад хүмүүст халдаах чадвартай болдог (3-р асуултыг үз).

7. Уушигны халдварт сүрьеэгээр өвчилсөн хүн хэр удаан халдвартай байх вэ?

Уушигны халдварт сүрьеэгээр өвчилсөн хүнийг эмнэлэгт буюу гэрт нь тусгаарлаж, өөрөөр хэлбэл цээр хориг тавин орчноос нь таслана. Ингэж халдваргүй болтол нь байлгана. Энэ нь ихэнхдээ хоёроос гурван долоо хоног үргэлжилдэг. Үүний дараа тэрээр халдваргүй болно. Гэхдээ эмчилгээг эмчийн хяналтын дор нийт зургаан сар ба түүнээс удаан хугацаагаар бүрэн эдгэртлээ хийлгэнэ.

8. Хэн халдвар авах эрсдэлтэй вэ?

Уушигны халдварт сүрьеэгээр өвчилсөн хүнтэй нягт ойр байсан (нэг өрөө тасалгаанд хэдэн цаг хамт байсан) хүмүүс л халдвар авах эрсдэлтэй (6-р асуултыг үз).



9. Би вакцин хийлгэсэн мөртлөө халдвар авч болох уу?

Болно, яагаад гэвэл урьд өмнө сүрьеэгийн эсрэг тогтмол хийгддэг байсан вакцин (BCG) нь халдвараас дутмаг хамгаалдаг юм.

10. Би уушигны сүрьеэтэй хүнтэй ойр байсан, тэгээд одоо би яах ёстой вэ?

Таны харъяа кантоны Уушигны өвчин анагаах газрын (*Lungenliga*) Сүрьеэгийн мэргэжлийн тасаг танд үнэгүй зөвөлгөө болон сүрьеэгийн талаарх бүх л асуудлаар мэдээлэл өгч туслана. Уушигны халдварт сүрьеэгээр өвчилсөн хүнтэй нягт ойртсон хүмүүс (6-р асуултыг үз) Сүрьеэгийн мэргэжлийн тасагт цаг тохирон ирж (хаягийг хавсралтаас үзнэ үү), мэдээлэл авч, мөн халдвар авсан эсэхээ шалгуулж болно. (12-р асуултыг үз).

11. Би уушигнаас гадуур сүрьеэгээр өвчилсөн хүнтэй ойр байсан, одоо би яах ёстой вэ?

Танд ямар ч аюул байхгүй. Тиймээс та ямар ч арга хэмжээ авах шаардлагагүй. Сүрьеэгийн ийм хэлбэрүүд халдваргүй байдаг, яагаад гэвэл өвчтөн сүрьеэгийн нянг агаарт гадагшлуулдаггүй юм.

12. Халдвар авсныг хэрхэн илрүүлэн тогтоох вэ?

Халдвар авсан эсэхийг арьсны туберкулины сорил, эсвэл цусны сорил (үүнийг бас гамма-интерферон-сорил гэж нэрлэдэг) -оор илрүүлнэ. Сорилын аргуудын тухай мэдээлэл болон сорилын үр дүнг хэрхэн тайлбарлах талаар харъяа кантоны Уушигны өвчин

анагаах газрын Сүрьеэгийн мэргэжлийн тасгаас асууж лавлана уу.

13. Арьсны туберкулины сорил ба/буюу цусны сорилыг 12-оос дээш насны хүмүүст яагаад уушигны халдварт сүрьеэгээр өвчилсөн хүнтэй хамгийн сүүлд ойртсоноос нь хойш найман долоо хоногийн дараа хийдэг юм бэ?

Сүрьеэгийн нян маш удаан үрждэг бөгөөд иммунологийн реакци нь хэдэн долоо хоногоор үргэлжилдэг. Тиймээс халдвар авсан эсэхийг найман долоо хоногийн дараа л илрүүлэх боломжтой байдаг. Харин 12-оос доош насны хүүхдүүдэд сүрьеэгийн аюултай хэлбэр бий болох магадлал өндөр. Түүнээс гадна энэ насанд өвчин илүү хурдан даамжирдаг. Иймээс энэ насны хүүхдүүдэд хамгийн сүүлд ойртсоны дараа шууд эхний сорилыг хийгээд, сорилын үр дүнгээс хамааран найман долоо хоногийн дараа дахин давтана.

14. Цусны сорилын хариу эерэг гэж гарлаа. Энэ юу гэсэн үг вэ, одоо яах вэ?

Сорилын хариу эерэг бол сүрьеэгийн нянтай ойртсон гэсэн үг (2-р асуултыг үз). Сүрьеэгийн мэргэжлийн тасаг үр дүнг таньд буюу таны өрхийн эмчид мэдэгдэж, сүрьеэгээр өвчилсөн эсэхийг тогтоохын тулд бусад үзлэг шинжилгээ (рентген зураг г.м.) -г хийлгэх цаг тохирохыг санал болгоно.

15. Би халдвар авсан байна, тэгэхээр би бусдад бас халдвар тарааж болно гэсэн үг үү?

Үгүй! Халдвар авсан гэдэг нь сүрьеэгээр өвчилсөн гэсэн үг биш, мөн халдвартай гэсэн үг ч биш (2, 4 ба 6-р асуултуудыг үз). Тиймээс

цусны шинжилгээний эерэг хариу нь таны ойрын хүмүүст аюулгүй.

16. Би халдвар авсан тохиолдолд хожим хойно сүрьеэгээр өвчлөх эрсдэл миний хувьд хэр өндөр вэ?

Таны биеийн эсэргүүцэл буюу дархлал нянг тогтоон барьж байдаг. Тиймээс нян унтаж байгаа мэт байдалд байна. Халдвар авсан бүх хүмүүсийн 90% нь сүрьеэгээр өвчилдөггүй. Харин үлдсэн 10% нь өвчилдөг бөгөөд түүний хагас нь эхний хоёр жилийн дотор, бусад нь түүнээс хожуу өвчилдөг (4-р асуултыг үз). Биеийн эсэргүүцэл хангалттай биш бол эрсдэл ихсэнэ (ж: ДОХ-ын халдвар авсан, удаан хугацаагаар кортизоноор эмчлүүлсэн, дархлал сульдаадаг химийн эмчилгээ хийлгэсэн, шижин өвчтэй, мөн согтууруулах ундаа буюу тамхи хэтрүүлэн хэрэглэдэг бол).

17. Хэрэв би халдвар авсан бол эмчилгээ хийж болох уу?

Халдвар авсныг илрүүлсэн бол (2-р асуултыг үз) антибиотикоор эмчилнэ. Эмчилгээ нь уг антибиотикоос хамааран дөрвөөс есөн сар үргэлжилнэ. Энэ эмчилгээг хийлгэх нь зүйтэй, яагаад гэвэл энэ нь хожим хойно өвчлөх эрсдлийг огцом багасгадаг. Халдвар авсан хүн эмчилгээ хийлгэх эсэхээ эмчилдэг эмчтэйгээ хамтран шийднэ.



18. Хэн юуг төлөх вэ?

Сүрьеэгийн талаарх төлбөрийн асуудал кантон бүрт өөр өөрөөр зохицуулагдсан байдаг. Танай кантоны Уушигны өвчин анагаах газрын Сүрьеэгийн мэргэжлийн тасаг танд тухайн кантонд үйлчилдэг журам заалтуудын талаар мэдээлэл өгч туслах болно.

19. Кантон бүрийн Сүрьеэгийн мэргэжлийн тасгуудаас гадна сүрьеэгийн талаарх асуудлуудаар хандаж болох Швейцарын улсын байгууллага бий юу?

Бий, Швейцар улсын Уушигны өвчин анагаах газрын Сүрьеэгийн Цогц чадварын төв (*Kompetenz-zentrum Tuberkulose*) гэж байдаг. Тэрээр Холбооны Эрүүл мэндийн албаны даалгавраар Үндэсний хэмжээний асуудлыг хариуцан ажилладаг. Түүний талаарх тодорхой мэдээллийг www.tbinfo.ch вэб хуудсаас олж үзнэ үү.

20. Орчин тойронд шинжилгээг яаж хийдэг вэ?

Сүрьеэ оношлогдсон тохиолдолд хариуцаж байгаа эмч өвчтөний харъяаллын кантоны эмчид түүнийгээ мэдэгдэх ёстой. Кантоны эмч үзлэг шинжилгээний дүнгүүд дээр тулгуурлан орчин тойронд шинжилгээ хийх шаардлагатай эсэхийг шийднэ. Уушигны сүрьеэгийн халдвартай хэлбэр оношлогдсон бол орчин тойронд шинжилгээ хийх шаардлагатай. Энэ тохиолдолд Уушигны өвчин анагаах газрын Сүрьеэгийн мэргэжлийн тасаг орчин тойронд шинжилгээ хийх үүрэг даалгавар авна. Тэрээр өвчтөнтэй холбоо барьж орчин тойрных нь халдвар авах эрсдэлтэй хүмүүсийн нэрийн

жагсаалтыг гаргана (8-р асуултыг үз). Тэдгээр нь ихэнхдээ гэр бүлийн хүмүүс, хамтран амьдрагчид, мөн хамт ажилладаг хүмүүс болон чөлөөт цагаа хамт өнгөрүүлдэг найз нөхөд нь байдаг. Тэдэнд бас мэдэгдэж, халдвар авсан эсэхийг тогтоох зорилгоор сорилд хамруулна (12-р асуултыг үз).

Та ...

...сүрьеэ нь Холбооны Эрүүл мэндийн албанд мэдэгдэх ёстой өвчнүүдийн нэг юм.

...сүүлийн жилүүдэд Швейцар улсад шинээр сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн тоо жилд 500-гаас 550 болон тогтворжсон.

...эмийг Швейцар улсын Уушигны өвчин анагаах газар ба Холбооны Эрүүл мэндийн албаны зөвлөмжийн дагуу хэрэглэвэл сүрьеэг сайн эмчилж болно.

... дэлхий дээр (юуны өмнө хөгжиж буй орнуудад) жил бүр 1,8 сая гаруй хүмүүс сүрьеэгээр нас бардаг.

... гэдгийг мэддэг байсан уу?

Мэдээллийн хуудас
FAQ бусад хэлээр:



Competence centre tuberculosis
Chutzenstrasse 10
3007 Bern
Phone 031 378 20 50
Fax 031 378 20 51
tbinfo@lung.ch
www.tbinfo.ch

Сүрьеэгийн мэрэгжлийн тасгууд

Aargau/Basel-Land

Lungenliga Aargau
Tel. 062 832 49 30
tuberculose@llag.ch
www.lungenliga-ag.ch

Basel Stadt

Kantonsärztlicher Dienst
Tel. 061 267 95 26
gsd@bs.ch
www.gesundheitsdienste.bs.ch

Bern

Tuberkulose-Beratung
Universitätsklinik für Infektiologie
Inselspital
Tel. 031 632 60 69
tb.info@insel.ch
www.infektiologie.insel.ch

Fribourg

Ligue pulmonaire fribourgeoise
Tel. 026 426 02 70
info@liguepulmonaire-fr.ch
www.liguepulmonaire-fr.ch

Genève

Centre antituberculeux, HUG
Tel. 022 372 95 44
cat.infirmieres@hcuge.ch
www.hug-ge.ch/pneumologie/tuberculose

Glarus

Lungenliga Glarus
Tel. 055 640 50 15
info@llgl.ch
www.llgl.ch

Graubünden

Lungenliga Graubünden
Tel. 081 354 91 00
info@llgr.ch
www.llgr.ch

Jura

Ligue pulmonaire jurassienne
Tel. 032 422 20 12
tuberculose@liguepj.ch
www.liguepj.ch

Luzern/Nidwalden/Obwalden/ Schwyz/Zug

Lungenliga Zentralschweiz
Tel. 041 429 31 10
info@lungenliga-zentralschweiz.ch
www.lungenliga-zentralschweiz.ch

Neuchâtel

Ligue pulmonaire neuchâteloise
Tel. 032 720 20 50
info@lpne.ch
www.lpne.ch

St. Gallen-Appenzell

Lungenliga St. Gallen
Tel. 071 228 47 47
Fax 071 228 47 48
info@lungenliga-sg.ch
www.lungenliga-sg.ch

Schaffhausen

Lungenliga Schaffhausen
Tel. 052 625 28 03
info@lungenliga-sh.ch
www.lungenliga-sh.ch

Solothurn

Lungenliga Solothurn
Tel. 032 628 68 28
info@lungenliga-so.ch
www.lungenliga-so.ch

Thurgau

Lungenliga Thurgau
Tel. 071 626 98 98
info@lungenliga-tg.ch
www.lungenliga-tg.ch

Ticino

Lega polmonare ticinese
Tel. 091 825 60 25
info@legapolm.ch
www.legapolm.ch

Uri

Lungenliga Uri
Tel. 041 870 15 72
lungenliga.uri@bluewin.ch
www.lungenliga-uri.ch

Valais

Ligue pulmonaire valaisanne
Tel. 027 329 04 29
liguepulmonaire@psvalais.ch

Vaud

Ligue pulmonaire vaudoise
Tel. 021 623 38 00
info@lpvd.ch
www.lpvd.ch

Zürich

Verein Lunge Zürich
Tuberkulose-Zentrum
Tel. 044 268 20 95
tb@lunge-zuerich.ch
www.lunge-zuerich.ch

Fürstentum Liechtenstein

Amt für Gesundheit
Tel. +423 236 73 34
info@ag.llv.li
www.llv.li